



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/161/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn

Гэрээт аудитор: Б.Оюунхэрлэн

Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	143
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	144
4. Аудитын илрүүлэлт	145
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.Аудитын санал дүгнэлт



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэргэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Ауд. 02.15 № 50

танай _____ -ны № _____ -т

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЧИМЭДДОРЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020806

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,649,090.00</u>	<u>22,848,538.44</u>
33	АВЛАГА	1,227,831.00	127,049.44
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,227,831.00	127,049.44
35	БАРАА МАТЕРИАЛ	22,421,259.00	22,721,489.00
351	Түүхий эд материал	15,128,820.00	16,287,020.00
35110	Тусгай зориулалттай материал	15,128,820.00	16,287,020.00
354	Хангамжийн материал	7,292,439.00	6,434,469.00
35410	Бичиг хэргийн материал	1,435,990.00	1,255,550.00
35420	Аж ахуйн материал	4,052,319.00	4,324,919.00
35440	Түлш, шатах тослох материал	950,130.00	
35450	Барилгын засварын материал	108,000.00	108,000.00
35470	Бусад хангамжийн материал	746,000.00	746,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,897,589,405.51</u>	<u>2,813,995,183.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,897,589,405.51	2,813,995,183.73
392	Биет хөрөнгө	1,948,884,405.51	1,863,801,641.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,331,142,946.00	1,331,142,946.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-42,975,238.46	-67,683,566.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,600,000.00	73,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,999,999.95	-8,999,999.91
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	99,519,910.00	102,179,970.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,382,771.42	-61,721,727.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	139,088,238.00	147,088,238.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-101,498,352.08	-117,943,192.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	420,778,721.00	420,778,721.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-306,389,047.58	-349,639,747.25
39216	Дуусаагүй барилга, байгууламж	395,000,000.00	395,000,000.00
393	Биет бус хөрөнгө	948,705,000.00	950,193,541.82
39301	Програм хангамж	2,020,000.00	3,520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,540,000.00	-1,551,458.18
39303	Бусад биет бус хөрөнгө	948,225,000.00	948,225,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,921,238,495.51</u>	<u>2,836,843,722.17</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,227,831.00</u>	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,227,831.00	
413	Өглөг	1,227,831.00	
4136	Бусад өглөг	1,227,831.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,227,831.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,920,010,664.51</u>	<u>2,836,843,722.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,920,010,664.51	2,836,843,722.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,656,272,448.00	2,656,272,448.00
51101	Өмч: - төрийн	1,708,047,448.00	1,708,047,448.00
51103	- хувьцаат	948,225,000.00	948,225,000.00

512	Хуримтлагдсан үр дүн	-370,143,719.99	-453,310,662.33
51210	Өмнөх үеийн үр дүн	-370,143,719.99	-370,143,719.99
51220	Тайлант үеийн үр дүн		-83,166,942.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	633,881,936.50	633,881,936.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,921,238,495.51	2,836,843,722.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	397,022,140.00	334,438,820.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,847,000.00	10,390,520.82
120	Нийтлэг татварын бус орлого	48,847,000.00	10,390,520.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,847,000.00	10,390,520.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,147,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,700,000.00	10,390,520.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	348,175,140.00	324,048,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	269,532,800.00	238,567,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	269,532,800.00	238,567,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,642,340.00	61,308,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		47,850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,642,340.00	10,974,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,484,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		24,172,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		24,172,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	458,587,527.60	417,605,763.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,587,527.60	417,605,763.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,770,485.29	387,234,354.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,053,583.30	171,918,626.00
210101	Үндсэн цалин	164,628,096.75	132,716,000.00
210102	Нэмэгдэл		39,202,626.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,425,486.55	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,776,030.94	22,135,349.02
210201	Тэтгэврийн даатгал	14,973,099.66	15,435,022.77
210202	Тэтгэмжийн даатгал	1,763,099.98	1,719,186.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,437,231.38	1,375,349.14
210204	Ажилгүйдлийн даатгал	402,599.96	327,799.20
210205	Эрүүл мэндийн даатгал	3,199,999.96	3,277,991.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,164,974.45	17,889,767.87

210301	Гэрэл, цахилгаан	2,224,999.45	1,447,887.87
210302	Түлш, халаалт	15,805,000.00	14,992,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,134,975.00	1,449,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,528,016.00	6,727,815.48
210401	Бичиг хэрэг	2,031,025.00	1,206,360.00
210402	Тээвэр, шатахуун	2,248,221.00	2,618,121.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,076,680.00	1,906,094.48
210404	Ном, хэвлэл	24,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	528,000.00	528,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	620,090.00	469,240.00
2105	Нормативт зардал	6,830,500.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,830,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,307,700.00	1,999,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	716,000.00	
210604	Урсгал засвар	6,591,700.00	1,999,800.00
2107	Томилолт, зочны зардал		690,000.00
210702	Дотоод албан томилолт		690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,924,488.00	3,898,303.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,490,500.00	2,701,017.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,860.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	
210807	Газрын төлбөр	1,417,128.00	1,197,286.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,185,192.60	161,974,693.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,700,450.00	66,489,951.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,484,742.60	95,484,742.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,817,042.31	30,371,408.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,796,080.00	23,584,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,315,180.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,480,900.00	22,424,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,502,937.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,502,937.06
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,962.31	5,284,271.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,962.31	5,284,271.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-61,565,387.60</u>	<u>-83,166,942.34</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-61,565,387.60</u>	<u>-83,166,942.34</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,656,272,448.00	633,881,936.50	-308,578,332.39	2,981,576,052.11
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,656,272,448.00	633,881,936.50	-308,578,332.39	2,981,576,052.11
C07	Тайлант үеийн үр дүн			-61,565,387.60	-61,565,387.60
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,656,272,448.00	633,881,936.50	-370,143,719.99	2,920,010,664.51
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,656,272,448.00	633,881,936.50	-370,143,719.99	2,920,010,664.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,656,272,448.00	633,881,936.50	-370,143,719.99	2,920,010,664.51
D08	Тайлант үеийн үр дүн			-83,166,942.34	-83,166,942.34
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,656,272,448.00	633,881,936.50	-453,310,662.33	2,836,843,722.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	349,322,140.00	324,048,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,147,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	1,147,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,147,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,147,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	348,175,140.00	324,048,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	269,532,800.00	238,567,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	269,532,800.00	238,567,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,642,340.00	61,308,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		47,850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,642,340.00	10,974,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,484,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		24,172,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		24,172,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	349,322,140.00	324,048,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	349,322,140.00	324,048,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,767,277.69	293,676,891.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,153,315.30	171,970,524.31
210101	Үндсэн цалин	164,628,096.75	132,716,000.00
210102	Нэмэгдэл		39,254,524.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,525,218.55	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,676,298.94	22,210,500.15
210201	Тэтгэврийн даатгал	14,973,099.66	15,496,242.90
210202	Тэтгэмжийн даатгал	1,763,099.98	1,721,586.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,337,499.38	1,377,299.14
210204	Ажилгүйдлийн даатгал	402,599.96	328,670.20
210205	Эрүүл мэндийн даатгал	3,199,999.96	3,286,701.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,208,414.45	17,889,767.87
210301	Гэрэл, цахилгаан	2,224,999.45	1,447,887.87
210302	Түлш, халаалт	15,700,000.00	14,992,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,283,415.00	1,449,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,142,361.00	5,247,845.48
210401	Бичиг хэрэг	1,749,330.00	893,320.00
210402	Тээвэр, шатахуун	3,198,351.00	1,703,591.00
210403	Шүүдан, холбоо, интернэтийн төлбөр	1,076,680.00	1,503,094.48
210404	Ном, хэвлэл	200,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	528,000.00	528,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	390,000.00	619,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,358,400.00	3,280,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,995,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,280,200.00
210604	Урсгал засвар	2,363,400.00	1,999,800.00
2107	Томилолт, зочны зардал		690,000.00
210702	Дотоод албан томилолт		690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,804,488.00	5,398,303.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,490,500.00	4,201,017.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,860.00	

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	
210807	Газрын төлбөр	1,297,128.00	1,197,286.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,424,000.00	66,989,951.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,424,000.00	66,989,951.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,554,862.31	30,371,408.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,533,900.00	23,584,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,053,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,480,900.00	22,424,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,502,937.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,502,937.06
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,962.31	5,284,271.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,962.31	5,284,271.13
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	262,739,800.00	255,953,130.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,739,800.00	255,953,130.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,155,600.00	232,368,930.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,159,600.00	171,970,524.31
210101	Үндсэн цалин	132,716,000.00	132,716,000.00
210102	Нэмэгдэл	39,443,600.00	39,254,524.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,241,600.00	22,210,500.15
210201	Тэтгэврийн даатгал	16,355,200.00	15,496,242.90
210202	Тэтгэмжийн даатгал	1,721,600.00	1,721,586.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,377,300.00	1,377,299.14
210204	Ажилгүйдлийн даатгал	344,300.00	328,670.20
210205	Эрүүл мэндийн даатгал	3,443,200.00	3,286,701.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,172,300.00	17,889,767.87
210301	Гэрэл, цахилгаан	4,167,300.00	1,447,887.87
210302	Түлш, халаалт	14,992,200.00	14,992,200.00

210303	Цэвэр, бохир ус	4,012,800.00	1,449,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,845,200.00	4,844,845.48
210401	Бичиг хэрэг	893,400.00	893,320.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,600.00	1,300,591.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,503,100.00	1,503,094.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	528,000.00	528,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	620,100.00	619,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,204,200.00	1,199,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	204,200.00	200,200.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	998,800.00
2107	Томилолт, зочны зардал	690,000.00	690,000.00
210702	Дотоод албан томилолт	690,000.00	690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,676,000.00	5,398,303.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,478,700.00	4,201,017.00
210807	Газрын төлбөр	1,197,300.00	1,197,286.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8166700.00	8165990.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,166,700.00	8,165,990.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23584200.00	23584200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,584,200.00	23,584,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,424,200.00	22,424,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,160,000.00	1,160,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	262,739,800.00	262,739,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	238,567,500.00	238,567,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	238,567,500.00	238,567,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,172,300.00	24,172,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	24,172,300.00	24,172,300.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	18
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	7	7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18	18
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17	17

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,307,961.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,307,961.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,307,961.00
2104	Хангамж, бараа материалын зардал	403,000.00
210402	Тээвэр, шатахуун	403,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,081,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,080,000.00
210604	Урсгал засвар	1,001,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,823,961.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,823,961.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,308,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,308,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,974,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,484,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар

болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, гэрээт аудитор Б.Оюунхэрлэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Биеийн тамир, спорт, идэвхтэй хөдөлгөөнөөр иргэдийн эрүүл мэндийг бэхжүүлэх, спортоор тогтмол хичээллэдэг иргэдийн тоог нэмэх, тамирчдын спортын амжилтыг олимп, тив, дэлхийн түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг.

Монгол Улсын Засгийн газрын 47 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороо байгуулагдаж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа биеийн тамир, спортын асуудал хариуцсан нэгжийг Улсын хороонд харьяалах чиглэлээр Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар хэлэлцэгдэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 458.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 22.7 сая төгрөг болж 0.3 сая төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,421.5 сая төгрөг болж 12.2 сая төгрөгөөр өссөн нь 1.5 сая төгрөгийн программ хангамж төсвийн хөрөнгөөр худалдан авсан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 10.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж шилжиж ирсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 62.9 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон бараа үйлчилгээний бусад зардлын санхүүжилт буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 41.0 сая төгрөгөөр буурсан нь бараа үйлчилгээний бусад зардал буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 391.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 391.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 262.7 сая төгрөгийн төсөв баталснаас 238.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 24.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 238.5 сая, орон нутгийн төсвөөс 24.2 сая нийт 262.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 255.9 сая төгрөг буюу 95.9 хувийн гүйцэтгэлтэй буюу 6.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагаанаас 2.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 58.8 сая, нийт 61.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс спортын тэмцээн уралдаан зохион байгуулах зардалд 58.8 сая, хөдөлмөр хамгааллын зардалд 1.1 сая, урсгал засварт 1.0 сая, шатахууны зардалд 0.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Биеийн тамир, спортын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2021 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг тоо мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 37.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1.0 сая төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага өгсөн.

4.1 Албан шаардлага

Бараа материалын худалдан авалтыг тухай бүрд нь бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 3 дугаар зүйлийн 3.1.1. “нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь” гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг; гэж заасантай нийцэхгүй байна.

Шатахуун зарцуулалтын бүртгэлгүй ажил гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

4.2 Төлбөрийн акт

Худалдан авалтын НӨАТ-ын баримтыг тулган үзэхэд иргэн М.Мөнхтулгаас НӨАТ-ын баримт авч гүйлгээ хийсэн боловч ebarimt.mn төлбөрийн баримтын цахим системд тухайн баримт байхгүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан заавар, маягтын НХМаягт ТМ-5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.....Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Биеийн тамир, спортын газар	3	3.5			1	2.0	2	1.5		